

“Э-Транс ложистикс “ХК-ийн ТУЗ-ийн
2022 оны 10 сарын 21-ны өдрийн
... тоот тогтоолын хавсралт

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ баримт бичгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах бодлогыг тодорхойлно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:

2.1.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

2.1.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

2.1.3. компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.

2.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд уг шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах ба энэ баримт бичгийн 2.1-т заасан нөхцөл хангагдсан байна.

2.3. Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг дагаж мөрдөнө.

2.4. Ногдол ашигийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Тооцооллыг гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.

2.5. Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.6. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашигийг тараах өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.

2.7. Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашигийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байршуулна.

2.8. Ногдол ашиг тараасны дараа үлдэх ашгаас нийгмийн хариуцлага, соёлын арга хэмжээний санг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр байгуулж болно. Сан байгуулах, түүний хөрөнгийг захиран зарцуулах журмыг гүйцэтгэх удирдлага боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батална.

2.9. Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашигийг хугацаанд нь тараагаагүй тохиолдолд

хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанийд учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.